



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/МБ.

Алтрага

Малын гоц халдварт шүлхий өвчний
вакцинжуулалтын арга хэмжээг зохион
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, аймгийн Засаг даргын 2024 оны А/394 дүгээр захирамж, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/35 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нийт үхэр сүргийг вакцинжуулах ажлыг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд чанартай зохион байгуулахыг “Чанартай сүрэг” ХХК-ийн захирал (Л.Дүүжий), “Агар Мөрөн ЭНТ” хоршооны дарга (Б.Тунгалагтуул)-нарт даалгасугай.
2. Дархлаажуулалтын ажлыг шуурхай зохион байгуулан, шаардагдах хүн хүч, шатахуун, унаа тээврээр ханган ажиллахыг сумын Онцгой комиссын нарийн бичгийн даргад, харьяа багийнхаа нийт үхэр сүргийг дархлаажуулалтад хамруулахыг багийн Засаг дарга нарт хариуцуулсугай.
3. Дээрх арга хэмжээг удирдан зохион байгуулах мэргэжил арга зүй, удирдлагаар ханган, вакцин, ариутгалын бодис татан авч хуваарилах, дархлаажуулалтын мэдээ тайланг холбогдох газарт хүргүүлэн ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархварзүйч (Д.Энхтайван)-д үүрэг болгосугай.
4. Вакцинжуулалтын ажлын бэлтгэлийг ханган цахим бүртгэл, мэдээллийг тухай бүр нь ирүүлэх, вакцин тариур, зүү, бусад багаж хэрэгслийг бүрдүүлж ажиллахыг малын эмч нарт үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Даваажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГОДСЭР